



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/38

Модот

**Хязгаарлалтын дэглэм тогтоох  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Тус сумын Нугаар багийн/ “Шаврын шандын адаг” /N47.38343,Е108.4420,6/, “Их-Уул” /N47.3616,7, Е108.3753/ нэртэй газруудад малын гоц халдварт шүлхий өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн тул 2026 оны 03 дугаар сарын 23-наас тодорхойгүй хугацаагаар хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Малын гоц халдварт шүлхий өвчний сэжигтэй бүсэд хяналтын пост, хөдөлгөөнт эргүүл гаргаж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Б.Ганзоригт)-т, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг малчдад хүргэж ажиллахыг Нугаар багийн Засаг дарга (Б.Чулуунцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Малын гоц халдварт шүлхий өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн бүсийн малд болон Хэрлэнбаян-Улаан отрын бүс нутгаас нүүж ирсэн Нугаар багийн өрхүүдийн малд үзлэг тандалт халдваргүйтгэл хийх ажлыг “Дэрст хайрхан” Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч Б.Хатансайхан-д, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (П.Ганчимэг)-т хариуцуулсугай

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

